



**НИЙСЛЭЛИЙН  
БАГАНУУР ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ**

2023 оны 03 сарын 15 өдөр

Дугаар 4/66

Улаанбаатар хот

┌ Автотээвэр болон өөрөө явагч хэрэгслийн ┐  
албан татвар, агаарын бохирдлын төлбөр, авто  
зам ашигласны төлбөр төвлөрүүлэх зарим арга  
хэмжээний тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Автотээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татварын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2, Агаарын бохирдлын төлбөрийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.3, Авто замын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.3 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Дүүргийн хэмжээнд автотээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татвар, агаарын бохирдлын төлбөр, авто зам ашигласны төлбөр хураах, автотээврийн болон өөрөө явагч хэрэгслийн техникийн үзлэг, татварын хяналт, шалгалтыг удирдан зохион байгуулах үүрэг бүхий салбар комиссын бүрэлдэхүүнийг хавсралтаар баталсугай.

2. Бүх төрлийн тээврийн хэрэгслийн албан татвар, төлбөр хураах ажлыг 2023 оны 01 дүгээр сарын 03-ны өдрөөс 06 дугаар сарын 01-ний өдрийн хооронд зохион байгуулж, орлогыг төсөвт төвлөрүүлэн ажиллах, албан татвар, төлбөрөө төлөөгүй авто тээврийн хэрэгсэл эзэмшиж буй иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын дутуу төлөлтийг хураан барагдуулах, хариуцлага тооцох хяналт шалгалтын ажлыг зохион байгуулж, үр дүнг тухай бүр танилцуулж ажиллахыг Комиссын дарга (Б.Балжинням)-д даалгасугай.

3. Дүүргийн салбар комиссын гишүүдэд дараах арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай.

3.1. Албан татвар, төлбөр хураах ажлыг нутаг дэвсгэрийн зарчмаар зохион байгуулан, тухайн нутаг дэвсгэрт авто тээврийн хэрэгсэл эзэмшиж буй иргэн, аж ахуйн нэгж, байгууллагыг бүрэн хамруулж, өмнөх жилийн хамрагдалтын түвшинг нэмэгдүүлэн, нэг цэгийн хэлбэрээр зохион байгуулах;

3.2. Иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын албан татвар, төлбөрийг хуулийн хугацаанд Нийслэлийн замын сангийн дансанд төвлөрүүлэх, нийслэлийн 2023 оны төсвийн орлогын төлөвлөгөөний сар, улирлын хуваарийг мөрдөж ажиллах;

3.3. Албан татвар, төлбөр хураахтай холбогдсон мэдээ, мэдээллийг автотээврийн хэрэгслийн нэгдсэн цахим үйлчилгээ "smartcar.mn", Татварын удирдлагын нэгдсэн систем, гэрэгэ киоск төхөөрөмж ашиглан, төрийн цахим үйлчилгээний нэгдсэн портал Е-Монголиа системээр дамжуулж, албан татвар, төлбөрөө төлөх зар сурталчилгааг хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулан нийтэд түгээх, сурталчлах;

D:\2023\Zahiramj\Zahiramj.docx

1202010181